*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

БАЯНДУН СУМЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙЦААГЧ
БАЛДОРЖИЙН ДОЛГОРХАНДЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. "НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО ТӨВЛӨРҮҮЛЭХ, ХАМРАГДАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ ОЛГОХ"** | | | | | | | |
| 1. | Ажил олгогч, даатгуулагчдын хамралтыг нэмэгдүүлэн орлогын төлөвлөгөөг биелүүлэх, | Орлогын төлөвлөгөөг жигд биелүүлэн ажиллана. | | ***1309269.7 мянган төгрөг*** | Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жилийн хүрээнд тус онд шинээр байгуулагдсан "Улзын урт" ХХК, татварын албанд цалин хөлсний тайлан илгээж эхэлсэн "Сарт түргэн хонгор" ХХК-ийг шинээр хамруулснаар нийт 32 аж ахуйн нэгж, байгууллагын 222 албан журмын, сайн дурын даатгалын 308 даатгуулагчдыг хамруулж, эхний 11 сарын байдлаар орлогын төлөвлөгөө ***1213776.3 мянган төгрөг*** төвлөрч 92.7 хувийн биелэлттэй байна. | 2024.01.01-2024.12.31 | 92.7% |
| 2. | Ажил олгогч, даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан тооцоог нэгдсэн системд | Тайланг хугацаанд нь бүрэн авч хэвшинэ. | | 32 аж ахуйн нэгж, байгууллага | Тайлант хугацаанд 32 аж ахуйн нэгжийн 999572.8 мянган төгрөгийг төвлөрүүлж, товлолт хугацаанд нь цахимаар илгээлгэж, нэгдсэн системд бүрэн татагдсаны дараа 100 хувь | 2024.01.01-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хянаж баталгаажуулах, | | | | цаасаар хүлээн авч, хянаж баталгаажуулсан. | | |
| 3. | Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, авлагыг бууруулах, | Хуримтлагдсан авлага үүсгэхгүй ажиллах, 50 хувийг барагдуулах | | 2228.3 мянган төгрөг | Шимтгэлийн авлага барагдуулах аяны хүрээнд 32 аж ахуйн нэгж, байгууллагын 1-11 сарын өглөг авлагын тайлан дахь 2228.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар 4 байгууллагад мэдэгдэл өгсөн. Авлагын насжилтаар 90-ээс дээш хоногийн хугацаатай "Дун түшиг", "Дун-Эрдэнэ" ХХК-ийн 1584.3 мянган төгрөгт албан шаардлага хүргүүлсэн. Тайлант онд өглөг, авлага үүсгэхгүй ажиллана. | 2024.01.01-2024.12.31 | 100% |
| 4. | Ажил хөдөлмөр эрхлээгүй иргэд болон малчдыг сайн дурын даатгалд хамруулан гэрээ байгуулж, шимтгэлийг төлүүлэх, | Сайн дурын даатгалын хамралт нэмэгдсэн байна. | | 225 даатгуулагч | Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жилийн хүрээнд малчдын сайн дурын даатгал төлөлтөд анхаарч, нийт 105 малчин хамруулахаас 205 малчдын 96125.7 мянган төгрөгийн шимтгэлийг төлүүлж, 68892.2 мянган төгрөгийн төрөөс үзүүлэх хөнгөлөлтөнд хамруулсан. Сайн дурын даатгалын энгийн төрөлд 120 даатгуулагчдыг хамруулахаас 50 даатгуулагчийн 30558.6 мянган төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөө 41.6 хувьтай байна. Нийт дүнгээр 255 малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй, оюутан даатгуулагчдын 195576.5 мянган төгрөг төвлөрч, төлөвлөгөө 106.1 хувиар биелсэн. | 2024.01.01-2024.12.31 | 100% |
| 5. | 0-3 насны хүүхэдтэй эх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийг сайн дурын даатгалд хамруулан | Бүрэн хамруулсан байна. | | 100 даатгуулагч | Хөдөлмөр халамж, үйлчилгээний мэргэжилтнээс 0-3 насны хүүхдээ асарч, мөнгөн тэтгэмж авч байгаа 114 эхийн судалгаанд үндэслэхэд нийгмийн даатгалын хамралт 29.8 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гэрээ байгуулж, шимтгэлийг төлүүлэх, | | | | хувьтай, 80 эх хамрагдах боломжтой судалгаа гарсан. Эхчүүдийн 70 хувьтай холбогдож, нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулснаар 11 сарын байдлаар 45 эхийг сайн дурын даатгалд хамруулж, төлөвлөгөөний биелэлт 50 хувьтай байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 10 эхийг сайн дурд хамруулах төлөвлөгөөтэйгөөс 8 эхийг хамруулсан биелэлт 80 хувьтай байна. | 2024.01.01-2024.12.31 | 53% |
| 6. | Даатгуулагчдаас тэтгэвэр, тэтгэмжийн баримтыг хүлээн авч мэдээллийг нэгдсэн системд бүртгэн тогтоолт, олголтыг хугацаанд нь гүйцэтгэх, | Тэтгэвэр, тэтгэмжийг хугацаанд нь олгоно. | | Тухай бүр | Тайлант онд өндөр насны 23, хөгжлийн бэрхшээлтэй иргэний 3, тэжээгчээ алдсаны 1 тэтгэвэр авагчдын тэтгэврийг шинээр тогтоож, сум хариуцсан байцаагчаар мэдээллийн нэгдсэн системд бүртгүүлэн, олголтыг бүрэн хийлгэсэн. Цалин өөрчлүүлэх хүсэлт гаргасан 2, ажилласан жил нэмүүлэх 5, тэтгэврийн 20 хувийн нэмэгдэл авах 8 тэтгэвэр авагчдад зохих нэмэгдлийг хийлгэж, хугацаанд нь олгуулсан. Оршуулгын тэтгэмжийн 10 өргөдлийг шийдвэрлүүлж, ажилгүйдлийн 11, жирэмсэн амаржсаны болон хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн 52 хүсэлтийг хүлээн авч порталаар илгээхэд зөвлөж, хугацаанд нь шийдвэрлүүлсэн. | 2024.01.01-2024.12.31 | 100% |
| 7. | Нийгмийн даатгалын үйлчилгээтэй холбоотой мэдээ судалгаа, тайлан гаргах, | Чанартай гаргаж хугацаанд нь хүргүүлнэ. | | Тухай бүр | Нийгмийн даатгалын газраас ирсэн хугацаатай судалгаа, төсвийн төсөөлөл болон НДЕГ-ын даргын 01 тоот албан даалгавар, “Болзолт уралдаан”-ы тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн. | 2024.01.01-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8. | Улсын байцаагчийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавин ажиллах; | Бүрэн барагдуулж ажиллана. | | Тухай бүр | Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах сарын аяны хүрээнд сумын 4 аж ахуйн нэгжид ирсэн 2158.6 мянган төгрөгийг барагдуулах тухай улсын байцаагчийн албан шаардлагыг танилцуулж төлүүлсэн. Урьд оны тэтгэврийн илүү олголтод тавигдсан улсын байцаагчийн актын дагуу 1 тахир дутуугийн тэтгэвэр авагчын 650.0 мянган төгрөгийн төлөлтийг хувааж хийлгүүлснээр бүрэн барагдуулсан. Системийн хэмжээнд шинэ программд шилжсэнтэй холбоотойгоор Сургуулийн хүүхдээ асарч байгаа 1 эх, Цэцэрлэгийн хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжтэй байсан 1 даатгуулагчийг тайланд тусгалгүй тайлагнасанд тавигдсан 2 актын 282.5 мянган төгрөгийн шимтгэл төлбөрийг бүрэн төлүүлсэн. | 2024.01.01-2024.12.31 | 70% |
| **Зорилт 2.** "ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ " | | | | | | | |
| 1. | Ажил олгогч, даатгуулагчдад Нийгмийн даатгалын багц хууль болон бусад хууль тогтоомжийн талаар сурталчилгаа хийж зөвлөгөө өгөх, цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх | Ажил олгогч, даатгуулагчдын мэдлэг дээшилнэ. | | 500 иргэнд мэдээлэл хийх | Нийгмийн даатгалын багц хууль, шинээр мөрдөгдөж байгаа хуулийн сурталчилгааг 01 сард багийн ИНХ-д оролцож нийт 205 малчдад хүргэсэн. Мөн алслагдсан малчин өрхийн 55 гишүүнд гарын авлага хүргүүлж, олон нийтийн цахим хуудсаар 129 удаа мэдээллийг түгээсэн. Даатгуулагчдад и-монголия болон портал цахим системийн ашиглалтын талаар зөвлөгөөг өгч ажилласан. | 2024.01.01-2024.12.31 | 100% |
| 2. | Ажил олгогчдын нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг | Тоо гарын үсгийн хэрэглээг бүрэн | | 5 аж ахуйн нэгж, байгууллага | Нийгмийн даатгалын үйлчилгээ системийн хэмжээнд шилжсэнтэй холбоотойгоор одоогоор тоон гарын | 2024.01.01-2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тоон гарын үсгээр баталгаажуулан хүлээн авах, | нэвтрүүлнэ. | | | үсгээр тайлангаа илгээхгүй байна. | | |
| 3. | Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг иргэд даатгуулагчдад /https://portal.ndaatgal.mn/ сурталчилан, ашиглаж сургах, мэдээлэл түгээх | Даатгуулагчид цахим программ ашиглаж сурсан байна. | | 550 иргэн | E-mongolia болон Даатгалын системээр хандаж нийгмийн даатгалын цахим үйлчилгээг авах талаар иргэдэд цахимаар болон биеэр сурталчлан ажилласан. Сайн дурын даатгалын гэрээ байгуулах 216 даатгуулагчийн хүсэлтийг порталаар илгээлгэж шийдвэрлүүлсэн. Ажилгүйдлийн болон жирэмсэн амаржсан, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн хүсэлтээ илгээх 85 даатгуулагчид порталаар хүсэлтийг явуулахад зөвлөж ажилласан. Гар утасны аппликейшнийг ЗДТГ, Эрүүл мэндийн төв, Цэцэрлэгийн 58 албан хаагчдад гар утсанд нь татан суулгуулж, бүртгэлжүүлсэн. | 2024.01.01-2024.12.31 | 100% |
| 4. | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилт, өөрчлөлт, үйлчилгээний талаар сумын удирдлага, ЗДТГ-ын ажилтнуудад мэдээлэл өгөх | Нэгдсэн мэдээлэлтэй болж, ажил төрлийн уялдаа сайжирна. | | Улиралд 1-ээс доошгүй удаа | Нийгмийн даатгалын холбогдох мэдээллийг 7 хоног бүрийн Даваа, Лхагва гарагийн хуралдаанд танилцуулдаг. Нийгмийн даатгалын ажилтны өдрийг угтан ЗДТГ-ын мэдээллийн цагаар 25 албан хаагчдад мэдээлэл өгч, танин мэдэхүйн "АХА" тэмцээн зохион байгуулсан. Багийн Засаг дарга нарт хуулийн холбогдох заалтуудыг танилцуулж, малчдад хүргэх мэдээлэл, гарын авлагыг тогтмол өгч ажилласан. | 2024.01.01-2024.12.31 | 100% |
| 5. | Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулахад бүтээлч | Үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн | | Улиралд 1-ээс доошгүй удаа | Жил бүр уламжлал болгон нийгмийн даатгалын ажилтны өдрөөр үйл ажиллагаагаа сурталчлан танин мэдэхүйн "АХА" тэмцээнийг нийгмийн | 2024.01.01-2024.12.31 | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шинэ санаачлага гарган ажиллах, | байна. | | | даатгалын мэдээллийг бататгах зорилгоор явуулж хэвшсэн. | | |
| **Зорилт 3. "ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ "** | | | | | | | |
| 1. | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, шаардлагатай бусад тоо баримт, удирдлагаас хүргүүлсэн мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг хугацаанд нь гаргаж тайлагнасан байна. | | Тухай бүр | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, шаардлагатай бусад тоо баримт, удирдлагаас хүргүүлсэн мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн. | 2024.01.01-2024.12.31 | 100% |
| 2. | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | Хуульд заасан заавар журмыг зөрчихгүй ажилласан байна. | | Тухай бүр | Иргэдээс ирсэн тэтгэвэр тогтоолгох 27, тэтгэврийн 20 хувийн нэмэгдэл авах 8, цалин өөрчлүүлэх 2 болон тэтгэмж авах 73 өргөдлийг хүлээн авч хуулийн хугацаанд шиидвэрлүүлсэн. Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж, холбогдох сургалтанд 2 удаа хамрагдсан. | 2024.01.01-2024.12.31 | 100% |
| 3. | Албан хэрэг хөтлөлтийн заавар, баримт бичгийн стандартыг дагаж | Стандарт, зааварт нийцүүлэн | | Тухай бүр | Албан хэрэг хөтлөлтийн заавар, баримт бичгийн стандартыг дагаж мөрдөж ажиллаж байна. | 2024.01.01-2024.12.31 | |

10

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мөрдөж ажиллах; | ажилласан байна. | | | | | |
| 4. | Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан, зогсоогдсон хувийн хэрэг болон бусад баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгөх; | Архив, бичиг хэрэг хөтлөлтийн зааврын баримтлан ажиллана. | | Тийм | Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан, зогсоогдсон хувийн хэрэг болон сайн дурын даатгуулагчийн гэрээ бусад баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгдөг. Шинээр тогттоолгосон 27 тэтгэвэр авагчийн хувийн хэргийг цахимд оруулсан. | 2024.01.01-2024.12.31 | 100% |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх | Чанартай гаргаж хугацаанд нь хүргүүлнэ. | | Тухай бүр | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажилласан. | 2024.01.01-2024.12.31 | 100% |
| 2. . | Аймгийн Засаг даргын 02 тоот албан даалгаврын хүрээнд иргэд, малчдад учирч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх сургалт талаарх сурталчилгаа хийж, нийгмийн даатгалд хамруулах аян зохион байгуулах | Иргэд даатгуулагчид ойлголтыг бүрэн авч, хамрагдалт нэмэгдсэн байх | | 20 | Аймгийн Засаг даргын 02 тоот албан даалгаврын хүрээнд иргэд, малчдад учирч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх амь насны даатгалын талаарх мэдээллийг багийн Иргэдийн Нийтийн Хуралд 2 удаа, цахим сүлжээгээр 52 удаа хийж, жилд 2 удаа тайлагнасан. Сайн дурын даатгалд дээрх аяны хүрээнд 35 малчныг сайн дурын даатгалд хамруулсан. | 2024.01.01-2024.12.31 | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуусан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Нийгмийн даатгалын Ерөнхий газар, Нийгмийн даатгалын газар, аймгийн ЗДТГ, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан сургалтанд хамрагдах | Зохион байгуулсан сургалтанд бүрэн хамрагдсан байна. | | | Нийгмийн даатгалын Ерөнхий газрын цахим сургалтанд 1 удаа, , Нийгмийн даатгалын газрын 2, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “7:4:10” сургалтанд 5 удаа хамрагдсан. | 2024.01.01-2024.12.31 | |
| 2. | Монгол бичгийн мэдлэгээ сайжруулах | Монгол бичгээр уншиж, компьютерт бичдэг болох | | | Динамик платформоор surgalt.ndaatgal.mn системд өөрийн эрхээр нэвтрэн Монгол бичгийн сертификат олгох цахим сургалтад хамрагдсан. Сумын Насан туршийн боловсролын төвийн багшийн заавраар монгол бичгээр унших, бичих чадвараа сайжруулж, Чимээ аппликейшн ашиглаж сурсан. | 2024.01.01-2024.12.31 | |
| 3. | Нийгмийн даатгалын нэгдсэн системийг ашиглаж, үйлчилгээнд нэвтрүүлэх | Нэгдсэн системийг ашиглахад суралцах | | | Нийгмийн даатгалын нэгдсэн системийн ашиглалт сумдад эхлээгүй төвийн байцаагч нараар дамжуулан үйлчилгээнд хамруулж байна. Ажил | 2024.01.01-2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | олгогчдын нийгмийн даатгалын тайлан, тэтгэмжийн хүсэлтийг порталаар илгээх үйлчилгээнд бүрэн нэвтрүүлсэн. Даатгуулагчдад сайн дурын гэрээ байгуулах, тэтгэмжийн хүсэлт гаргах үйлчилгээг бүрэн эзэмшүүлэхээр зөвлөмжийг хүргэж ажилладаг. | | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Баяндун сумын Нийгмийн даатгалын улсын байцаагч
*( Албан тушаал )*

............................. / Б.Долгорханд /
*( Нэр, гарын үсэг )*

2024.12.06
*( Огноо )*